

**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ  
САНХҮҮЖҮҮЛЭХ ТАЛААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН  
ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

**Нэг. Ерөнхий мэдээлэл**

Хууль тогтоомжийн тухай хууль<sup>1</sup>-ийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.” гэж заасны дагуу “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл /цаашид “тогтоолын төсөл” гэх/ батлагдсан нөхцөлд түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хуулийн төслийн үр нөлөөг урьдчилан тандан судлах явцад гүйцэтгэх нь тухайн эрх зүйн зохицуулалтын үр нөлөөгөөр хүрэхийг хүссэн үр дүн, түүнийг хэрэгжүүлэх тогтолцоог бий болгоход зарцуулах зардлын харьцааг тогтооход чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэхүү үнэлгээний зорилго нь хуулийн төсөл батлагдсанаар иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад шинээр үүсэх зардлын ачааллыг урьдчилан тооцож, цаашид гарах зардлыг багасгах санал боловсруулахад оршино.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход доор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан болно. Үүнд

- иргэн, төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;<sup>2</sup>
- үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;<sup>3</sup>
- бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;<sup>4</sup>
- аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.<sup>5</sup>

Аргачлалын Ерөнхий зүйлийн 1.5-д заасан журмын дагуу зардлыг (1) төрийн байгууллагын зардал, (2) хуулийн этгээдийн зардал, (3) иргэнд үүсэх зардал гэсэн гурван төрлөөр тооцдог. Харин тус хуулийн төсөл батлагдсанаар иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад зардал үүсгэх зохицуулалт тусгагдаагүй тул аливаа нэмэлт болон шинэ зардал гарахааргүй байна.

---

<sup>1</sup> 2015 оны 5 дугаар сарын 29-ний өдөр батлагдаж, тухай бүр нэмэлт, өөрчлөлт орсон Хууль тогтоомжийн тухай Монгол Улсын хууль <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11119>

<sup>2</sup> Аргачлалын 2.3, 4.3 дахь хэсэг

<sup>3</sup> Аргачлалын 2.4.4, 4.4 дэх хэсэг

<sup>4</sup> Аргачлалын 4.4.3.1 дэх дэд заалт

<sup>5</sup> Аргачлалын 2.1, 4.1 дэх хэсэг

**Хоёр. “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдсанаар хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцоо**

Энэ хэсэгт тогтоолын төсөл батлагдсанаар хуулийн этгээдийн эрхлэх үйл ажиллагаатай холбоотой гүйцэтгэх үүргийн улмаас ямар нэг нэмэлт ажиллагаа хийгдэхгүй бөгөөд аливаа зардал үүсэхгүй болно.

Тогтоолын төсөлд хуулийн этгээдэд шинээр үүрэг хүлээлгэсэн, зардал бий болгосон зохицуулалт байхгүй байна.

**Гурав. “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдсанаар иргэнд үүсэх зардлын тооцоо**

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тусгагдсан иргэнд шинээр гүйцэтгэх үүрэг хүлээлгэсэн, зардал бий болгох зохицуулалт байхгүй байна.

**Дөрөв. “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдсанаар улсын төсөвт үүсэх зардлын тооцоо**

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлд төрийн байгууллагад шинэ чиг үүрэг нэмэгдүүлсэн зохицуулалт тусгаагүй тул улсын төсөвт шинээр зардал үүсэхээргүй байна.

---oOo---